

Есүс Христийн Хоёр дахь ирэлтээр амьд ба нас барсан хүмүүст юу тохиох вэ?

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

1 Тесалоник 4:13–18-ыг уншаад, Есүсийг дахин ирэх үед зөв шударга хүмүүст юу тохиох талаарх ойлголтыг хайж ол. Нас барсан болон Хоёр дахь ирэлтийн үеэр амьд байгаа хүмүүст тохиолдох зүйлсийн ялгааг онцол. (Эдгээр шүлэг дээрх “нойрсогчид” ба “нойрсогч” гэсэн үгс нь нас барсан хүмүүсийг хэлж байгаа болно.) 1 Тесалоник 4:15, 17-ийн Иосеф Смитийн Орчуулгыг унших нь тустай байж болох юм (15-р шүлэг, зүүлт тайлбар а, ба 17-р шүлэг, зүүлт тайлбар а-д).

- Эдгээр шүлэг дээрх юу нь танд ач холбогдолтой байсан бэ?

Дараа нь Сургаал ба Гэрээ 88:96–98-ыг уншаад, эдгээр үйл явдлын талаар нэмэлт ойлголтыг олж мэд. (Та мөн 99–101-р шүлгийг уншин, энэ амьдралдаа Есүс Христийг хүлээн аваагүй хүмүүст юу тохиолдох талаар олж мэдэж болно.)

- Та ямар ямар нэмэлт ойлголтыг олж авсан бэ?

Та Хоёр дахь ирэлтээс өмнө нас барсан үнэнч гэгээнтнүүд Христийг дахин ирэх үед амилуулагдах болно гэх үнэнийг тодорхойлсон байж болох юм.

“Өргөгдөх” (1 Тесалоник 4:17) гэх нэр томъёо нь Аврагчийн ирэлтээр Түүнтэй уулзахаар хамтдаа нэгдсэн зөв шударга хүмүүсийг хэлж байна. Христэд итгэгч олон хүн энэ цаг үеийн талаар ярихдаа *хөөрөх* (“өргөгдөх” гэсэн утгатай латин нэр томъёоноос гаралтай) гэх үгийг ашигладаг.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн энэхүү ариун үйл явдлын талаар дараах зүйлийг хуваалцсан.



Христийн тухай ярих хүслийг маань Түүний эргэн ирэхийг төсөөлөх төсөөлөл хамгийн их бадраадаг. Түүний хэзээ ирэхийг бид мэдэхгүй ч Түүний эргэн ирэх үеийн үйл явдлууд үнэхээр гайхалтай байх болно! Тэрээр бүх ариун тэнгэр элчийнхээ хамт сүр хүч хийгээд агуу алдар суугаар тэнгэрийн үүлэн дотор ирэх болно. Зөвхөн цөөн хэдэн тэнгэр элч ч биш бүр бүх ариун тэнгэр элчтэйгээ ирнэ. Энд Валентины картан дээрээ хардаг Рафаэлын зурсан улаан хацартай херубимын тухай яриагүй байна. Тэд бол олон зуун дамнан арслангуудын амыг тагласан, шоронгийн хаалгуудыг нээсэн, Түүний удаан хүлээсэн төрөлтийг тунхагласан, Түүнийг Гетсеманид тайвшруулсан, Түүнийг тэнгэр лүү дээш явах үед шавь нарт нь амлалт өгсөн мөн сайн мэдээний гайхамшигт Сэргээлтийг нээсэн тэнгэр элч нар юм.

Хөшигний энэ эсвэл нөгөө талаас нэгэн цагт Түүнтэй уулзахаар өргөгдөх болно хэмээн та төсөөлж чадах уу? Энэ бол зөвт хүмүүст өгөх Түүний амлалт юм. Энэхүү гайхамшигтай үйл явдал бидний бодгалийг мөнхөд өөрчлөх болно. (Нийл Л.Андэрсэн, “Бид Христийн тухай ярьдаг,” *Ensign*, Nov. 2020, 91 эсвэл 2020 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 99)

Аврагчийн ирэлтийн үеэр зөв шударга хүмүүсийн дунд тоологдох нь ямар байх талаар цаг гарган төсөөл.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ

- Тэр өдөр танд ямар бодол санаа эсвэл мэдрэмж төрж болох вэ? Ирэх үед нь таныг Өөртэй нь нэгдээсэй хэмээн Аврагч хүсдэг болохыг мэдэх нь танд ямар санагдаж байна вэ? Тэрхүү ирээдүйн өдрийн талаар төсөөлөх нь өнөөдөр танд хэрхэн нөлөөлж байна вэ?

1 Тесалоник 4:18-д Паул гэгээнтнүүдийг “эдгээр үгсээр бие биенээ тайвшруулах[ыг]” уриалсан.

- Паулын сургаал танд хэрхэн тайвшралыг өгч байна вэ? Тэдгээр нь ирээдүйд орж болох нөхцөл байдалд тайвшралыг хэрхэн өгөх вэ?